



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/344

Номгон

Шуурхай штаб байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйл, 27¹ дугаар зүйлийн 27¹.1.1, 27¹.1.6, 27¹.1.8, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын ажиллах журмын 1.6, аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамж, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2024 оны А/178 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хур борооны улирал эхэлсэнтэй холбогдуулан үер усны аюул ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах аймгийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-ыг байгуулж ажиллуулсугай.

2.Шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааг зохион байгуулах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Аймаг, сумын онцгой комиссын “Шуурхай штаб”-ыг удирдлага, зохион байгуулалтаар ханган, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн (Б.Батсуурь)-т үүрэг болгосугай.

4.Үүссэн нөхцөл байдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж сум орон нутгийн шуурхай штабт дэмжлэг үзүүлж мэргэжлийн удирдлагаар ханган тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт хариуцсан орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

824010833

Аймгийн Засаг даргын *2024* оны
06 дугаар сарын *07* ны өдрийн *134* дүгээр
захирамжийн *1* дүгээр хавсралт.

ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Нэр	Албан тушаал
1.	Дарга: Б.Батсуурь	Аймгийн Засаг даргын орлогч;
2.	Орлогч дарга: Б.Мягмарсүрэн	Аймгийн онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа;
3.	Д.Энхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга;
4.	Гишүүд: Т.Хишигбаатар	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;
5.	С.Байгалмаа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
6.	Ц.Батхүү	ЗХ-ний 339-р ангийн захирагч, хурандаа;
7.	Б.Мөнхбаяр	Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа;
8.	Н.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын дарга;
9.	Д.Алтангэрэл	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга;
10.	Г.Энхбаяр	Баянхонгор сумын Засаг дарга;
11.	С.Амармөнх	Автотээврийн төвийн дарга;
12.	Ж.Уламбаяр	Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ийн захирал;
13.	М.Мөнхбат	Чандмань-Баянхонгор ХК-ийн захирал;
14.	Ч.Оюунчимэг	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга;
15.	Б.Баярсайхан	Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК-ийн орон нутгийн салбарын дарга;
16.	М.Мөнгөнцэцэг	Улаан Загалмайн хороон дарга;
17.	Д.Одсүрэн	"Их богдын зам" ХХК-ын захирал;
18.	Нарийн бичиг: Г.Баярсайхан	Онцгой байдлын газрын ГХТББХАМ, ГХУХБайцаагч, хошууч;
19.	Б.Буяндэлгэр	Онцгой байдлын газрын УСАХМ, ахлах мэргэжилтэн.

-----oO-----

Аймгийн Засаг даргын 024 оны 06
дугаар сарын 07-ны өдрийн 1344 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

УДИРДАМЖ

Шуурхай штаб байгуулах тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага зохицуулалтаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, тулгамдсан асуудлыг Улсын онцгой комиссын шуурхай штабт танилцуулан шийдвэрлэх, холбогдох хүч хэрэгслийг татан оролцуулах, Засгийн газар, Улсын онцгой комиссыг шуурхай мэдээ, мэдээллээр хангах чиг үүрэгтэй ажиллана.

Хоёр. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Штабын бүрэлдэхүүн 09:00-17:30 цаг хүртэл ажиллах бөгөөд 17:30 цагаас дараагийн өдрийн өглөөний 09:00 цаг хүртэл Онцгой байдлын газрын Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төв, аймгийн Онцгой Комисст мэдээ мэдээллийг нэгтгэн танилцуулах;

Шаардлагатай тохиолдолд штабын даргын шийдвэрээр Шуурхай штабыг ажлын тусгай горимоор (уртасгасан цагаар) ажиллуулах;

Штаб нь гамшиг, аюулт үзэгдэл, томоохон хэмжээний ослын нөхцөл байдалтай уялдуулан гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аймаг, сум дүүргийн Онцгой комиссын үйл ажиллагааг зохицуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангах;

Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээ, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

Үүссэн нөхцөл байдалд төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөө, удирдлагын баримт бичгийг боловсруулж, тодотгох;

Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд холбогдох сум, хүн хүч, техник хэрэгсэл татан оролцуулах, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албадын хүч хэрэгслийг татан оролцуулах, хуваарилах;

2.

Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материалын судалгааг гаргах, дайчлах, бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

Үүссэн нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийх, хариу арга хэмжээг төлөвлөх;

Байгууллага аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн хандив тусламжийг хүлээн авах, тараах, зохицуулах;

Нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг нэггэн Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комисст танилцуулах;

Иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагыг гамшиг аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хариу арга хэмжээний тухай мэдээ, мэдээллээр хангах;

Шаардлагатай тохиолдолд Шуурхай штабын гишүүдийг гамшгийн голомтод томилон ажиллуулж удирдлагаар хангуулах,

Үүссэн нөхцөл байдалд газар дээр нь очиж ажиллах, шуурхай албаны автомашинаар хангуулах;

Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа ажилтан, алба хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн томилон харьяалах байгууллага ажилтанд нэмэгдэл хөлс, цалин, урамшуулал, гамшгийн голомтод ажилласан томилолт олгох асуудлыг шийдвэрлүүлэх;

Гурав. Шуурхай штаб, штабын дарга, орлогчийн эрх, үүрэг

Шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

Улсын онцгой комисс, Аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Өмнөд бүсийн төв, Онцгой байдлын газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;

Гамшиг, цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг үүсэх эрсдэл, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөж зохион байгуулах;

Шаардлагатай бараа материал, техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний нөөцийн судалгааг гаргах, зохицуулах;

Улсын онцгой комисс, Аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Өмнөд бүсийн төв, Онцгой байдлын газрын болон аймаг, сумдын Онцгой комиссын үйл ажиллагааг уялдуулах, мэдээ, мэдээллийг цахим технологийн түвшинд шуурхай солилцох;

Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх арга хэмжээг хуулийн хугацаанд шуурхай зохион байгуулах;

Шуурхай штабын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.

Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтаар хангах, холбогдох түр журам, заавар батлах;

Шуурхай штабын багуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гүйцэтгэлд хяналт тавих;

Шуурхай штабын бүрэлдэхүүн, сумын болон орон нутгийн шуурхай штабуудад үүрэг, чиглэл өгөх, биелэлтийг хангуулах, хяналт тавих;

Шуурхай штабын үйл ажиллагааны тайлан, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг сар тутам аймгийн Онцгой комисст танилцуулах;

Улсын онцгой комисс, Аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Өмнөд бүсийн төв, Онцгой байдлын газрын болон аймаг, сумдын Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр аймгийн Онцгой комисст тайлагнах;

Улсын онцгой комисс, Аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Өмнөд бүсийн төв, Онцгой байдлын газрын болон аймаг, сумдын Онцгой комиссын гишүүд болон холбогдох албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангах;

Хоногийн нөхцөл байдлын мэдээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Онцгой комиссын дарга, Аймгийн онцгой комиссын орлогч дарга, аймгийн онцгой комиссын нарийн бичгийн даргад өдөр тутам танилцуулах;

Хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч Шуурхай штабын бүрэлдэхүүний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ээлжийн зохион байгуулалтад оруулах, ажлын цагийн зохицуулалт хийх, шаардлагатай бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Шуурхай штабын орлогч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

Шуурхай штабын даргын өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах, Шуурхай штабын багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, өдөр тутам хяналт тавих;

Шуурхай штабын багуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хянах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Шуурхай штабын даргыг мэдээллээр хангах;

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Шуурхай штабын багуудын тавьсан санал, хүсэлт, шийдвэрлэх асуудлыг Шуурхай штабын даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

Шуурхай штабын бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил, амралтын цагийг зохицуулах, эрүүл мэндийг хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах;

Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэрийн төсөл, Шуурхай штабын тайлан, аймгийн онцгой комисс болон олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийг хянаж, Шуурхай штабын даргад хүргүүлэх

Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Аймгийн Онцгой комисс, Өмнөд бүсийн төв, Онцгой байдлын газрын болон аймаг, сумдын Онцгой комисс, иргэд, олон нийтийг үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллээр хангах;

Шуурхай штабын бүрэлдэхүүний сахилга, хариуцлага, ажилласан цагийн тооцоо, ажил үүргийн гүйцэтгэлтэд хяналт тавих.

3.4 Нарийн бичиг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ

Шуурхай штабын дарга, орлогч нарт дотоод ажлын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажиллах;

Аймаг, сум, Шуурхай штабуудтай харилцан ажиллах, мэдээлэл солилцох;

Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллагааг зохион байгуулах, багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

Шуурхай штабын хоногийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэх;

Шуурхай штабын гишүүдийн эрх, үүрэг

Штабын бүрэлдэхүүн нь төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

Штабын гишүүд нь Гамшиг, цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг үнэн зөв хүлээн авч дамжуулна.

Штабын гишүүд нь холбогдох дарга, захирагч нарыг өгсөн үүрэг даалгаврын цаг тухайд нь биелүүлж, хариуцлагатай байх

Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн харьяалах байгууллагын удирдлагад тухайн ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгуулах асуудлыг Шуурхай штабын дарга шийдвэрлэнэ.

Дөрөв . Бусад зүйл

4.1 Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, саналыг тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.